



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/1170

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны явцад хяналт тавих журам”-ыг 1 дүгээр, “Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны судалгаа”-ны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2010 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Журам батлах тухай” 238 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг нийт албан хаагчдад болон газар, хэлтсийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571003506

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын 2020 оны дугаар тушаалын
дүгээр хавсралт

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГААР ШИЙДВЭРЛЭГДЭЖ БАЙГАА
ХЭРЭГ МАРГААНЫ ЯВЦАД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд шийдвэрлэлтийн явц, байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох, тэдний үйл ажиллагаа болон хэрэг маргааны шийдвэрлэлтийн явцад хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын нийт албан хаагч мөрдөж ажиллах ба журмын хэрэгжилтэд холбогдох газар, хэлтсийн дарга нар тогтмол хяналт тавьж ажиллана.

**Хоёр.Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох,
түүний эрх, үүрэг**

2.1.Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн тус газарт холбогдох албан ёсны мэдэгдэл /мэдэгдэх хуудас, албан бичиг г.м/-ийг хүлээн авсан албан тушаалтан Тамгын газрын Захиргаа, эрх зүйн хэлтсийн бичиг хэргийн эрхлэгчид даруй хүлээлгэн өгч, ирсэн албан бичгийн бүртгэлд бүртгүүлэх бөгөөд бичиг хэргийн эрхлэгч холбогдох албан тушаалтанд шилжүүлнэ.

2.2.Хууль хяналтын байгууллагаас эрүү, иргэн, захиргааны хэрэгт тус байгууллагыг хариуцагч, хохирогч, гэрч, гуравдагч этгээдээр татах тухай албан ёсны мэдэгдэл /мэдэгдэх хуудас, албан бичиг г.м/-ийг үндэслэн хэрэгт хамаарал бүхий газар, хэлтсийн даргаас саналыг авч, саналын дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох албан бичгийн төслийг хуулийн мэргэжилтэн боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргад танилцуулж, батлуулна.

2.3.Журмын 2.2-т дурдсан итгэмжлэгдсэн төлөөлөгчийг орон нутагт тухайн нэгжийн дарга томилно.

2.4.Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон албан бичгийн эх хувийг, мэдэгдэх хуудсын хамт итгэмжлэгдсэн төлөөлөгчид гардуулах ажлыг албан бичгийн төсөл боловсруулсан албан хаагч хариуцан гүйцэтгэнэ.

2.5.Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан эрхийг эдлэхээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

2.5.1.хууль хяналтын байгууллагын дуудсан хугацаанд очиж, нэхэмжлэл, хариу тайлбар зэргийг гардан авах, тэдгээрт өгөх хариу тайлбарын төслийг нотлох баримтын хамт бэлтгэн газар, хэлтсийн ахлах мэргэжилтэн/, улсын

ахлах бүртгэгч болон газар, хэлтсийн даргаар давхар хянуулан хуулийн хугацаанд эрх бүхий байгууллагад гарган өгөх /орон нутагт хэлтэс, тасгийн даргаар хянуулах/;

2.5.2.хэрэг маргааны талаар бүртгэлийн хувийн хэргийн эх нотлох баримтад үндэслэн сайтар судалж, холбогдох тайлбарыг бэлтгэх, тайлбарт шаардлагатай нотлох баримтуудыг архивын хувийн хэрэг, эх нотлох баримтаас гаргуулан авч, хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулан хавсаргаж, бүрэн гүйцэд гаргаж өгөх;

2.5.3.шүүх хуралд биечлэн оролцох, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжгүй болсон тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулах тухай хүсэлтээ хуулийн дагуу тавьж шийдвэрлүүлэх, энэ талаар газар, хэлтсийн даргад заавал мэдэгдэх;

2.5.4.бие даан шийдвэрлэхэд бэрхшээлтэй, нарийн төвөгтэй асуудлыг холбогдох чиглэлийн газар, хэлтсийн даргад танилцуулан чиглэл, зөвлөмж авах, итгэмжлэгдсэн төлөөлөгч нэмж томилуулах хүсэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргад тавьж шийдвэрлүүлэх /орон нутагт хэлтсийн даргад хандах/;

2.5.5.хэргийн бодит нөхцөл байдал, холбогдох хууль тогтоомжийг сайтар судлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

2.5.6.бүх шатны шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжийг хүлээн авмагц газар, хэлтсийн даргад танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

2.5.7.хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн мэдэгдэх хуудас, шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж, нэхэмжлэл зэрэг холбогдох албан бичгийг дарагдуулах, хайхрамжгүй хандах буюу удирдлагаас шийдвэр гаргахад аливаа байдлаар саад учруулах, цаг алдах, томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцохгүй байх, маргалдаж буй талуудын аль нэг талд давуу байдал үүсгэх, хувийн харилцаа тогтоохыг хориглоно.

Гурав.Хяналтыг хэрэгжүүлэх, тайлагнах

3.1.Газар, хэлтсүүд хууль хяналтын байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны талаар бүртгэл тогтмол хөтөлж, шүүхийн шийдвэр, холбогдох баримтыг хавсарган нэгтгэнэ.

3.2.Улсын бүртгэлийн ерөнхий газрын газар, хэлтсүүд харьяа албан хаагчдын оролцсон хэрэг маргааны шийдвэрлэх явцын талаарх судалгаа, тайланг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу гаргаж тухайн хугацаанд шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрийн хуулбарын хамт тогтоосон хуулийн хэлтэст цахимаар болон шаардлагатай тохиолдолд цаасан хэлбэрээр ирүүлнэ.

3.3.Газар, хэлтсүүд хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж буй шүүхийн шийдвэр, захирамж, албан тоот зэргийг холбогдох журмын дагуу бүртгэлийн хувийн хэрэгт хийнэ.

3.4.Шүүхийн шийдвэр, захирамж, албан тоот зэргийг хуулбарлан цахим хэлбэр /PDF файл/-аар хуулийн хэлтэст хүргүүлнэ.

3.5.Энэ журмын 3.2-т заасан судалгааг ерөнхий газрын газар, хэлтсүүд 7 хоног бүрийн Баасан гаригт, орон нутаг дахь газар, хэлтсүүд дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ.

3.6.Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг холбогдох нэгжээс сар бүрийн 25-ны өдөр судалгаагаар гаргаж хуулийн хэлтэст хүргүүлнэ.

3.7.Хуулийн хэлтэс нь газар, хэлтсүүдээс ирүүлсэн хэрэг маргааны шийдвэрлэлтийн явцын талаарх судалгааг нэгтгэж, нэгдсэн бүртгэл хөтөлнө.

Дөрөв.Бусад зүйл


4.1.Албан хаагч нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад гэм хор учруулсныг Улсын бүртгэлийн ерөнхий газар хариуцан арилгасан бол өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс хуулийн дагуу шаардаж гаргуулна.

4.2.Шүүхэд гарган өгөх нотлох баримтыг нотариатаар батлуулсан тохиолдолд холбогдох зардлыг ерөнхий газар, орон нутагт тухайн нэгж хариуцна.

4.3.Энэхүү журмыг зөрчсөн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

--oOo--

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын 2020 оны дугаар тушаалын
 дугаар хавсралт



Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны судалгаа

№	Итгэмжлэлийн огноо, дугаар	Нэхэмжлэгч	Хариуцагч /Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон албан хаагч/	Гуравдагч этгээд /Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон албан хаагч/	Нэмж эсхүл сольж томилогдсон албан хаагч	Нэхэмжлэлийн агуулга /Эрхийн улсын бүртгэлийн дугаар/	Хэргийн шийдвэр-лэлтийн явц	Шүүхийн шийдвэрийн огноо, агуулга	Шүүхийн шийдвэрээр байгууллагаас гаргуулахаар шийдсэн төлбөр	Хариуцсан шүүгч	Тайлбар
Нэгж: ...											